



**ХЭНТИЙ АЙМАГ
БЭРХ ХОТЫН ЗАХИРАГЧИЙН
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 09 сарын 05 өдөр

Дугаар Б/18

Бэрх

О.Мөнхбаярыг ажилд
томилох тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 67 дугаар зүйлийн 67.4, 67.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь заалт, “Төрийн албаны тухай” хуулийн 41 дүгээр зүйлийн 41.3 дахь заалт, “Хөдөлмөрийн тухай” хуулийн 47 дугаар зүйл, 48 дугаар зүйлийн 48.1, 49 дүгээр зүйлийн 49.1, 50 дугаар зүйлийн 50.1 дэх заалт, Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” 128 дугаар тогтоолын 11 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Захирагчийн ажлын албаны жижүүрээр Очирхуяг овогтой Мөнхбаярыг 2024 оны 09 дүгээр сарын 05-ны өдрөөс эхлэн томилсугай.
2. Жижүүрээр томилогдсон О.Мөнхбаярыг ТҮ-1 шатлалаар 900.000 /есөн зуун мянга/ төгрөгөөр цалинжуулахыг Нягтлан бодогч /Г.Осгонжаргал/-д зөвшөөрсүгэй.
3. О.Мөнхбаярт албан тушаалын тодорхойлолтод заагдсан зорилтыг хэрэгжүүлэх, байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг мөрдлөг болгон ажиллахыг үүрэг болгосугай.

ДАРГА



Э.МЯГМАРСҮРЭН